

Copyright © 2017 by the Kalmyk Scientific Center of the Russian Academy of Sciences



Published in the Russian Federation  
Bulletin of the Kalmyk Institute for Humanities  
of the Russian Academy of Sciences  
Has been issued since 2008  
ISSN: 2075-7794; E-ISSN: 2410-7670  
Vol. 34, Is. 6, pp. 2–36, 2017  
DOI 10.22162/2075-7794-2017-34-6-2-36  
Journal homepage: <http://kigiran.com/pubs/vestnik>

UDC 94

## A Translation and Study of the Mongolian Khan's Edicts in the *Goryeoosa* (1270–1280)

Boldbaatar Ariunbaigali<sup>1</sup>

<sup>1</sup> Postgraduate Student, National University of Mongolia (Ulaanbaatar, Mongolia). E-mail: [ariunbaigali@num.edu.mn](mailto:ariunbaigali@num.edu.mn)

**Abstract.** The *Goryeoosa* is the principal source of official Korean history (정사. 正史) critical to studying that period of history and including data on politics, economy, society, culture, and biographies of public figures of the Goryeo Dynasty. Therefore, wide ranges of studies have been done on *Goryeoosa* in South Korea such as history study, manuscript analysis, literature study and culture studies.

Our scholars have studied the *Goryeoosa* in great detail, e. g. in such works as *Correspondent Letters of Mongolia and Korea between the 13th and 14<sup>th</sup> Centuries* by B. Sumiyabaatar, *Tradition of Communication between Mongolia and Korea* by B. Lkhagvaa, etc.

There is a lot of information and facts related to Mongolia in the *Goryeoosa*, and when it comes to certain figures, one can mention 136 letters sent from Mongolia to Goryeo and 171 letters sent from Goryeo to Mongolia from 1218 to 1294 included into the *Goryeoosa*'s 'Sega' Section identified by Sc. D. B. Sumiyabaatar in his research. The present articles examines 620 communication letters and other related information and facts of the two countries recorded between the years 1270 to 1280, and shows additional detailed studies of the *Goryeoosa* to be conducted by Mongolian scholars are significantly required.

The paper aims to insure letters and edicts sent by the Great Khan of the Mongol Empire to the Goryeo Kingdom by stressing information and facts related to Mongolian language, culture, historical monuments, polities and foreign relations as described in the *Goryeoosa*'s 'Sega' Section (1270–1280) which contains important information about the history and culture of the Middle Ages of not only Korea but also those of Mongolia.

The mentioned 'Sega' Section (1270–1280) contains a total of 620 documents related to Mongolia of which 34 ones are edicts and records about the edicts sent by the Mongolian Great Khan to Goryeo, of which 16 papers in Chinese and 18 ones contain their related information.

The titles indicate edicts sent to Goryeo's King by the Mongolian Great Khan during the period under consideration can be divided into two main sections, namely: firstly, letter documents, and, secondly, edicts or instruction edicts.

The five edicts of the total 34 edicts are referred to as 'edicts' or 'shengzhi (聖旨)' in an ancient Korean copy of the *Goryeoosa*. The others are referred to as 'letters' in the original. This is based on an ancient Korean hardcopy since we have no Mongolian copy of the edicts. Therefore, this research leads us to reclaim what edicts and letters in the dynastic period actually are, including their forms and distinctiveness.

Several dozens of communication and official letters related to different periods of Mongolian history have survived as real hardcopies and indirect copies. The documents transcribed by the Mongolian Great Khan and his royal princes can be deliberated by categorizing as of edicts, words, letters and authorized passages. This explains what the king's edicts are, i. e. letters and written transcripts in relation to our subject.

The edict is “a decree and resolution issued by the Great Khan in Mongolian is 'zarlig', while a direction and decree by other king's royalty, queens, heads of regions, ministers and officials is called 'word', and this can be viewed as the uniqueness of chancellery recording of the Dai Yuan Dynasty which expands around 100 years from the declaration of the Dai Yuan Empire by Kublai Khan in 1260 to Toghon Temur Khan's leaving Daidu in 1368”.

Edicts of Mongolian Kings begin with “*Under the Eternal Universe's Power*” and the translation of the word in Chinese is 上天眷命; the phrase is commonly used in all edicts and letters once passed in the written form under administration of the Great Yuan Empire.

The Dai Yuan Empire's Khan's edicts were called differently — 'shengzhi' (聖旨) and 'zhao' (詔), and this was strictly observed. 'Shengzhi' is a Chinese translation of the word 'edict' from Mongolian, while 'zhao' means 'edict' as originally written in Chinese.

The above mentioned edicts had been originally written in Mongolian or square script, and were later translated into Chinese. However, there is no Chinese translation of the phrase “*Under the Eternal Universe's Power*” which is written in beginning of the Mongolian Khan's edicts. Except for this, considering whether the original Mongolian edict was translated to Chinese raises the question where the original Mongolian hardcopy is. Also, these are not full length edicts and their indirect data drawing our major interest. This might be explained in connection with the Square Script. The letter of January - 'black dog day' — 1273 notes that “... the King has received the Huangdi's letter brought by Yuan Empire's ambassador, but it was written in newly created Mongolian script and there was no person to translate, thus, the Mongolian ambassador provided contents description”. The newly created Mongolian script is certainly the Square Script. The Square Script had been created in 1269, and from that period onward the edicts and orders were written in Square Script, not in the traditional Mongolian script. This can be found in late Korean information source: “There are two types form in Mongolian script. One is called Uigurjin (Mongolian script) while another one is Durvuljin (Square Script). In the early time, the Square Script (Durvuljin) was used in letter and official documents and Mongolian script was used in running every day matters”. The edicts of Kublai Khan on spreading of the Square script provided a very clear paragraph about it: “Any jade stamp and issued edicts should be written in new Mongolian script (square script) and attach other national script with it”. Thus, from here we may draw an assumption that the edicts studied here had been sent to Goryeo not only written in Square Script, written in Chinese, and the edicts noted in the *Goryeosa* may have direct reflection of that.

Examining the edicts sent to Goryeo by the Mongolian Great Khan from 1270 to 1280 included in the *Goryeosa* and among them the edicts submitted in 1273, one can clearly see all of them were indirect implications. From this perspective, the edicts subject to our study here can be separated into three categories by their contents, namely the edicts with their contents fully noted, the edicts with contents not fully noted in Chinese and only briefly noted contents, and the edicts with contents not noted at all.

a) The edicts with contents fully noted or as full Chinese source. Edicts of this type number 16. On those could not see content's general form and phrase words of Mongolian official document uniqueness of that time period. It can be explained as followed.

1. From the Kublai Khan's period, the Great Khan's edicts begin with “*Under the Eternal Universe's Power, with Great Ingenious Benevolence Khan's Edicts this is*”, i. e. the three rows of firm phrases, and on the above edicts these phrases are absent.

2. These edicts were written as 'zhao' (or 'letter') in Chinese that raises the probability of them having been written in Chinese from the start.

Based on these, the edicts discussed here were noted in the *Goryeosa* not as Mongolian original script but rather written keeping content and compositing Korean sources form by breaking the Chinese script's distinctiveness.

b) The edicts with contents not fully noted, and only brief content noted in Chinese original. These types of edicts number 13 within the scope of our study. This can be explained by that as firstly the edict's content and importance were not so high therefore it was probably just briefly noted.

Nonetheless, one cannot deny the connection between the introduction of Square Script or new script and the fact that the Great Khan's letters had not been fully recorded. At least two of the Mongolian Great Khan's letters were received a year, and as was mentioned previously the letters sent from January of 1273 to August of 1274 and received during this a year and seven month period,

i. e. the six Grand Khan's letters, were not fully noted in the source and only its content was written and this draws great interest.

c) The ambassador came to Goryeo from Mongolia, and we found four records about the contents of the letters which were not noted but only described the arriving date of the ambassador in Goryeo and how the Grand Khan's letter was brought and received. These letters may be connected to the reputation and sore truth of history of the Goryeo dynasty. If the above mentioned information existed, the King's transcript minister should have at least briefly noted the content of the letter, not mentioning writing in full. Whereas, it was not noted at all and this attracts significant interest.

This may be explained, in some way, in connection with Yan Seongji (양성지. 梁誠之)'s proposition of: "The "Goryeoosa" have many notes about protest and unrest and describes bare truth in many instances ... protests and unrests were not only in the previous dynasty, it is present in any country at any generation, he underlined that the Goryeo dynasty cannot be compared with land owned by under Chinese medieval royals, and this should not be reason of the point of the matter, even "The History of Yuan" is spread by the Ming dynasty, the Goryeoosa should not be held and not spreading, if there is something not to be exposed there is a way to distribute leaving sensitive sections" ... in 1451, the Goryeoosa was ready but for long time it had not been announced, and the government was demanded to announce it many times in the year 1469.

**Keywords.** *Goryeoosa (History of the Goryeo Dynasty'*, Mong. *Guulin ulsyn sudar*), Mongolian Khanate, Kublai Khan, decree (Mong. *zarlig*), charter (Mong. *zuu bichig*)

## Оршил

«Гуулин улсын судар» бол Солонгосын албан түүх (정사. 正史)-ийн нэг бөгөөд Корйө (Гуулин)<sup>1</sup> улсын улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, төр нийгмийн зүтгэлтнүүдийн намтар зэргийг багтаасан, тухайн үеийн түүхийг судлахад хамгийн чухал тулгуур сурвалж юм. Тиймээс ч БНСУ-д «Гуулин улсын судар»-ыг түүх судлал, эх бичиг судлал, утга зохиол судлал, соёл судлал зэрэг талын асар их судалгаа хийсэн байдаг.

«Гуулин улсын судар»-ыг манай эрдэмтэн судлаачид чамгүй судлажээ. Тухайлбал, Б. Сумьяабаатарын «XIII–XIV зууны Монгол Солонгосын харилцааны бичгүүд», Б. Лхагваагийн «Монгол Солонгосын харилцааны уламжлал», Ц. Цэрэндоржийн «XIV зууны сүүлч үеийн Зүүн Азийн олон улсын байдал ба Умард Юань–Корёгийн харилцаа», Г. Эрдэнэчимэгийн «Монгол Солонгосын харилцаанд төрийн ураг барилдлагын гүйцэтгэсэн үүрэг (XIII–XIV зуун)»,

<sup>1</sup> 918–1392 оны хооронд Солонгосын хойгт оршиж байсан төрт улс. Бид энэхүү өгүүлэлд Х зууны үеэс дэлхий нийтэд танигдах болсон “고려 (高麗)” улсыг «Корйө», эл улсын түүх болох “고려사 (高麗史)-г «Гуулин улсын судар» хэмээн тэмдэглэв. Ер, монголчууд эрт үеэс Солонгосыг «Гаули улс, Гуулин улс», «Кори», «Солонго», «Солонгос», «Солхо» гэж хэд хэдэн янзаар нэрлэж ирсэн тухай доктор Б. Сумьяабаатар «XIII–XIV зууны Монгол Солонгос харилцааны бичгүүд»-дээ онцолжон байдаг.

түүнчлэн 2016 онд бидний нийтэлсэн «Гуулин улсын судар» өгүүлэл зэрэг болно.

«Гуулин улсын судар»-т Монголтой холбоотой мэдээ баримт их бий бөгөөд түүнээс зарим нэг тоо баримтыг онцлох аваас «Гуулин улсын судар»-ын «Сурвалжит гэр»-ийн 1218–1294 оны хэсэгт холбогдох мэдээнд Монголоос Корйөд илгээсэн 136 захидал бичиг, Корйөгөөс Монголд илгээсэн 171 захидал харилцааны бичиг буйг доктор Б. Сумьяабаатар судлан гаргасан байдаг [Б. Сумьяабаатар 1978; 2015] бол бидний судалгаагаар 1270–1280 онд холбогдох мэдээнд 2 улсын харилцааны бичиг болон бусад холбогдох мэдээ баримтууд 620 орчим буйгаас үзэхэд манай эрдэмтэн судлаачид «Гуулин улсын судар»-ыг нарийвчлан судлах нэн шаардлагатай нь харагдаж байна.

Тус өгүүлэлд Солонгос төдийгүй, дундад зууны Монголын түүх, соёлын талаарх чухаг мэдээ зангийг агуулдаг «Гуулин улсын судар»-ын «Сурвалжит гэр»-ийн 1270–1280 оны хэсэгт буй манай улсын хэл, соёл, түүх дурсгал, улс төр, гадаад харилцаатай холбоотой мэдээ баримтыг шүүн, тэдгээрээс Корйөд илгээсэн Монголын их ханы жуу бичиг, зарлиг заавруудыг нягталж үзэхийг зорилоо.

## Монголын их хаан Корйө улсын ванд илгээсэн зарлигийн бичгүүд (1270–1280)

«Гуулин улсын судар»-ын «Сурвалжит гэр»-ийн 1270–1280 оны хэсгийг шүүн үзэхэд Монголтой холбоо бүхий нийт 620 орчим мэдээ тэмдэглэгдэн үлдсэн байна.

Эдгээрийн дотор 1270–1280 онд Корийн улсад илгээсэн Монголын их хааны нийт 34 зарлигийн бичиг (Үүнд зарлиг, сургах зарлиг, жуу зэргийг хамтатган зааж буй агаад тэдгээрийг цаашид нийтэд нь зарлигийн бичиг гэх болно.) болоод зарлигийн бич-

гийн тухайт мэдээ тэмдэглэгдэж хоцорчээ. Тэдгээрийн 16 нь Монголын их хааны зарлигийн бичгийн нанхиад эх бол 18 нь тэдгээрийн тухайт мэдээ байна. Тус зарлигийн бичгүүдийг оны дэсээр доор хүснэгтлэн харуулав.

Монголын тухайт мэдээний ангиалал		1270	1271	1272	1273	1274	1275	1276	1277	1278	1279	1280	Нийт
<b>1</b> Монголын их хааны зарлиг, жуу бичиг		4	5	2		1	1	1			1	1	16
<b>2</b> Монголын их хааны зарлигийн бичгийн тухайт мэдээ			1		5	1	2	4		3		2	18

*Хүснэгт 1. 1270–1280 оны Корийн улсад илгээсэн Монголын их хааны зарлигийн бичгийн он дараалын задаргaa*

Хүснэгт 1-ээс үзэхэд 1270–1280 оны хооронд Монголын их хаан Корийн улс руу илгээсэн зарлигийн бичгүүдийн зарим нь л бүрэн эхээрээ эртний солонгос ханзаар үлдсэнийг мэдэж болохоор байна. Харин зарим хэсэг нь бүрэн эхээрээ бус, зөвхөн тэдгээрийн тухайт мэдээ төдийгөөр үлдсэн нь судлан буй зарлигийн бичгийн агуулга,

ач холбогдол, нууцлал зэрэгтэй холбоотой болохыг «Гуулин улсын судар»-ын оршил хэсгээс нягталж болмой [дэлгэрүүлэн үзнэ үү: Гадаад хэл соёл судлал 2016; Гуулин улсын судар 2016: 15–26; Ханъ Жөнхый 2008 (한정희, “국역고려사 1, 세가1”, 서울, 경인문화사, 2008)].

№	Он	Билгийн тооллын жил	Cap	Өдөр	Баримтын хэлбэр	Товч агуулга	Солонгос эх буй эсэх		
							тийм	дам	Угүй
1	1270	Цагаан морин жил, 11-р он	Өвлийн алаг сар Хөхгчин туулай		Жуу	Хуанди ванд өрнөдийн торго, цаг тооны бичиг буулгасан тухай.	√		
2					Жуу	Корийн улсын ванг «Чиний улс хэдүй жижиг авч бүтэн улсын ван гэдэг нь тодорхой тул бүхий л шагнал шийтгэл болон зөв бурууг чи л шүүн, шийдэх нь зүй болно. Хэрэв хуанди-д муу зүтгэх аваас гавьяа байгуулсугай хэмээн өрсөлдөх хүн маш олон...» хэмээн анхааруулсан тухай.	√		
3					Жуу	Бослого үймээнээс болгоомжилж, ард иргэдээ хамгаалахыг сануулсан тухай	√		
4					Жуу	Корийн улсын засгийн газрыг эх газар руу шилжүүлэхийг ухуулсан тухай.	√		

№	Он	Билгийн тооллын жил	Cap	Өдөр	Баримтын хэлбэр	Товч агуулга	Солонгос эх буй эсэх		
							тийм	дам	Үүй
5	1271	Цагаагчин хонин жил, 12-р он	Хаврын тэрүүн cap	Шарагчин туулай	Жуу	Элчийг газарчлан Японд хүргэх, түүнийг буцаж иртэл далайн эрэгт цэрэг суулгах тул тус хугацаанд шаардлагатай цэргийн хэрэгслийг бэлдэн нийлүүлэх тухай.	✓		
6				Улаан бар	Жуу	Корйө улсад албан тариалангийн цэрэг илгээж, хожим Япон руу довтлохоор төлөвлөсөн тухай.	✓		
7				Харагчин мөгой	Жуу	Вангийн гүрнээ айлчлахыг түдгэлзүүлсэн тухай.	✓		
8				Улаагчин мөгой	Жуу	Ванг 6000 цэрэг татаж, Чинъдо-г эзэл хэмээсэн тухай.	✓		
9				Улаан бич	Жуу	Хуанди ванг хэлсэн үгэндээ эзэн бол хэмээн сургасан тухай.	✓		
10				Улаан бар	Жуу				✓
11			Намрын эхэн cap	Цагаан бар	Зарлиг	Япон руу элчээр очиж гавьяа байгуулсан хүмүүсийг өндер албандаа дэвшүүл хэмээсэн тухай.		✓	
12				Хөхөгчин хонь	Жуу	Юань улс Чэжү-г дайлахаар ванд 6000 цэрэг, 3000 усчин шалгаруул хэмээн зааварласан тухай.	✓		

№	Он	Билгийн тооллын жил	Cap	Өдөр	Баримтын хэлбэр	Товч агуулга	Солонгос эх буй эсэх		
							тийм	дам	Үүй
13	1273	Х а р а г ч и н тахиа жил, 14-р он	Хаврын тэрүүн cap	Хар нохой	Жуу	Юань улсын элчийн авч ирсэн жууг шинэ зохиосон монгол үсгээр бичсэн тул тайлах хүн байсангүйд элч Им Йүгань-д «хүрэн баавгайн арьс ол» гэсэн утгатай гэж шивнэсэн тухай.	√	√	√
14				Хөхөгчин тахиа	Жуу	«Юань улсын цэргүүд сүм хийдэд үймээн шуугиан дэгдээхийг хориглон, лам хуврагуудыг сэтгэл амар байж, бурхны номоо айлдахтун» гэсэн тухай.			
15				Улаан бич	Жуу	«Хинъдү нарыг Тамра-руу захирагчаар томилсон.»			
16					Жуу	«Юань улсын цэргүүд бүсгүйчүүлийг шивэгчин болгож буйг хориглосон, Корйө улсыг зэвсэг хийхийг зөвшөөрсөн» тухай.			
17				Хар бич	Жуу	Юань улс их хатан болон тайжийг өргөмжилснөө элч илгээн мэдүүлсэн тухай.			
18			Намрын дунд cap	Зуны дунд cap	Зуны дунд cap	Газар тариаланг дэмжиж цэргийн хүнс нөөцөл хэмээсэн тухай.			
19				Цагаан хулгана	Жуу	Хуанди Корйө улсын угсаа залгамжлагчийг ван суурь залган, албаа гүйцэтгэ хэмээн зарлиг буулгасан тухай.			
20	1275	Хөхөгчин гахай жил, 16-р он	Зуны адаг cap	Зуны дунд cap	Шарагчин могой өдөр	Жуу	Хуанди Корйө улсын угсаа залгамжлагчийг ван суурь залган, албаа гүйцэтгэ хэмээн зарлиг буулгасан тухай.	√	√
21				Xөх нохой	Жуу				
22				Улаан луу	Жуу	Урьд Тамра-д бослого самуун гаргаад, жу хийн руу зайллан нуугдагсдыг ялаас чөлөөлсүгэй гэсэн тухай.			
			Цагаан нохой	Жуу	Корйө улсын Ван овогтынхон овог дотроо худ ураг холбодог явдал зүйд үл нийцэх, бидэнтэй ураг холбо, албан тушаалын нэршилийг зас хэмээсэн тухай.	√			

№	Он	Билгийн тооллын жил	Cap	Өдөр	Баримтын хэлбэр	Товч агуулга	Солонгос эх буй эсэх		
							тийм	дам	Үүй
23	1276	Улаан хулгана жил, 17-р он	Хаврын тэргүүн сар	Хаврын тэргүүн сар	Улаагчин үхэр	Жуу	Цаг тооны бичиг буулгасан тухай.	✓	
24					Хөхөгчин мөгөй	Сургах зарлиг	Ванг гүрнээ айлчлахыг түр түдгэлзүүлсэн тухай.		✓
25				Намрын адаг сар	Цагаан бич	Жуу	Өршөөх зарлиг буулгасан тухай.		✓
26					Хөх хулгана	Зарлиг	Ван, гүнж нарын гүрнээ айлчлах товыг 5 сард болгосон, цэргийн хангамжийн талаар зарлиг буулгасан тухай.		✓
27				Овлийн эхэн сар	Шар луу	Жуу			✓
28				Хар хулгана	Жуу	Цаг тооны бичиг зарлан тунхагласан тухай.		✓	
29				Шарагчин туулай	Жуу				✓
30				Хөх морь	Зарлиг	Ванг гүрнээ айлчлах зарлиг буулгасан тухай.		✓	
31	1279	Ш а р а г ч и н туулай жил, 20-р он	Хаврын тэргүүн сар	Хөхөгчин туулай	Жуу	Цаг тооны бичиг зарлан тунхагласан тухай.	✓		

№	Он	Билгийн тооллын жил	Cap	Өдөр	Баримтын хэлбэр	Товч агуулга	Солонгос эх буй эсэх		
							тийм	дам	үүгүй
32	1280	Цагаан луу жил, 21-р он	Хөвөлийн адаг Cap	Шар морь өдөр	Жуу	Хятад газрын гүн болон харьяа улсаас дутаасан цэрэг, уйгурчууд дураар мал нядлахыг хориглосон тухай.	✓	✓	✓
33				Цагаагчин гахай	Сургах зарлиг	Ванг гүрнээ айлчлах зарлиг буулгасан тухай.			
34				Цагаагчин туулай өдөр	Жуу	Корийн улсын ван, сайд түшмэдийг шагнасан тухай мэдээ.			

*Хүснэгт 2. 1270–1280 онд Корийн улсад илгээсэн Монголын их хааны зарлигийн бичгийн товч агуулга, хэлбэр, он дараалсан задаргаа, «Гуулин улсын судар»-т эх үлдсэн эсэх ангилал.*

Дээрх баримтууд одоогоор манай түүхийн судалгааны эргэлтэд хараахан орсон зүйл үүгүй. Бид энэ удаа 1270–1280 оны хооронд Монголын их хаан Корийн улсын ванд илгээсэн зарлигийн бичгүүдийг судлахдаа Тон-а их сургуулиас эрхлэн гаргасан «Гуулин улсын судар»-ыг эх хэрэглэгдэхүүн болгон ашигласан бөгөөд судлан буй зарлигийн бичгүүдийн монгол эх үүгүй тул эртний солонгос эхийг голчлон баримталсан болно. Өгүүлэн бүхүү зарлигийн бичгүүдээс хэсэгчлэн БНСУ-ын эрдэмтэд сурвалж судлал, хэл шинжлэлийн үүднээс судалсан судалгааны бүтээлүүд цөөнгүй [Паг Йөнрөг 2014; Паг Йөнрөг 2013; Ко Мийөнсү 2006; И Гайсөг 2014]<sup>2</sup> ба монгол хэлээр орчуулан гаргасан зүйл одоогоор байхгүй болохыг дурьдах нь зүйтэй болов уу.

<sup>2</sup> 朴英錄, “高麗史”에 수록된 蒙元公用語와 翻譯에 대한 검토, 大東文化研究 제 85집, 2014. 元代八思巴文獻研究導論, 충주대학교, 2009. “高麗史”蒙古直譯體白話牒文二篇의 解釋的研究, 中國言語研究 제 44 輯 2013. 고명수, “高麗史”‘世家’ 중 몽골 관계 기사 역주1, 한국중세사연구 제21호, 2006. 이개석, “高麗史”元宗忠烈王忠宣王세가 중 元朝關係記事의 研究, 동양사학연구, 제88집, 2004.

### Зарлигийн бичгүүдийн эртний солонгос эх ба монгол орчуулга

1. 1270 оны өвлийн адаг сарын хөхөгчин туулай өдрийн жуу бичиг 1

頃承世嫡來展壽儀雖歲事之有常見敬心之無替宜申寵錫用勤誠今賜卿西錦一段及曆日.”

«Хэдэн жилийн өмнө Корийн-гөөс ван хөвүүн<sup>3</sup> ирээд надад бараалхсан билээ. Тэр бол хэдүй жил бүр уламжлал болсон хэрэг боловч намайг хүндэтгэх сэтгэл нь хувиршгүй гэдгийг ойлгомуй. Зүй ёсоор буян хишиг соёрхож тэрхүү үнэнч сэтгэлийг нь хариулахын тул баруун газрын торго 1 толгой хийгээд цаг тооны бичгээршагнав.»

2. 1270 оны өвлийн адагсарын хөхөгчин туулай өдрийн жуу бичиг 2

“陪臣元傅等奏陳頭蟄哥國王行省官等擾害數事今使對辨皆是不實. 復言非卿親所聞見得之他人此殆非出卿意若輩小人所爲. 囊者卿嘗謂朕: ‘母聽小人之言.’ 朕諭之曰: ‘朕於小人之言或曾誤聽第朕不自知卿慎勿聽也.’ 自今觀之卿亦聽小人之言寧非顯然若輩小人又陳說前代故事暨祖宗法度雖有前代故事或卿祖宗法度豈無善與不善當擇其善者從之其不善者改之可也朕於卿

<sup>3</sup> Угсаа залгамжлах хөвүүн Ван Шим (왕심.王謙. Чхүнрийл ван).

豈肯用不善之心？若欲用不善之心當在去年矣。如前年有人言高麗與南宋日本交通嘗以問卿卿惑於小人之言：‘以無有。’爲對今年却有南宋商船來卿私地發遣迨行省致詰始言不令行省知會是爲過錯。又見有將到日本國歸附高麗人說：‘往者日本歲貢高麗。’又前年卿承當括兵造船至今未見成效托於林衍擅權事非由己。朕若此後再用小人卿寧復指以爲辭？卿國雖小卿亦是一國之王黜陟威福或是或非當自己出。如專任不善之人則不善之事止及卿身。天道悠遠事之未來者人孰預知就人事論之若輩小人於卿猶擅廢立於卿子孫豈肯盡心輔佐？朕與卿既爲一家籍我國家之力以威遠人自茲以往或南宋或日本若有事則兵馬戰艦資糧宜早措置儻依前託辭以營辦爲難則爭效成功之人甚衆。卿其思之。”

«Чиний түшмэл Вөнбүг (원부. 元傅) нарыг Тоуняньгэ Го ван (두련가국왕. 頭輦哥國王) болон Явах яамны түшмэл (행성관. 行省官) Корийд хэд хэдэн төвөгтэй хэрэг үүсгэсэн гэж илтгэсэнд, эдүгээ нүүрэлдүүлж байцаасны дүнд бүгд үнэний оргүй болох нь илрэв。Тэд бас, тэр хэргийг чамайг өөрөө сонсож, харсан хэрэг бус өөр хүнээс сонссон гэж өчсөн тул, үнэндээ бол чиний санаа биш тэр багачуудын худал үг ажгуу。Урьд чи надад “Өчүүхэн хүмүүсийн үгийг бүү сонс.” гэж зөвлөсөнд би ч гэсэн “Миний бие урьд өчүүхэн хүний үгийг сонсож алдаа гаргаснаа үл санамуй。Хойшид чи үргэлж болгоомжилж, өчүүхэн хүний үгийг бүү сонсогтун。” хэмээн ухуулсан билээ。Гэтэл одоо бодоход чи өөрөө ч гэсэн өчүүхэн хүний үгийг сонссон хэрэг нь илэрхий бусу?

Тэр багачууд ч гэсэн бас л эртний хувь дүрэм, эцэг өвгөдийн хууль ёсыг удтал ярих нь эртний хууль дүрэм, танай эцэг өвгөдийн хууль ёс буй хэдий ч түүнд ч гэсэн сайн муу зүйл яахин үгүй билээ? Түүн дотроос сайныг нь авч, саарыг нь засах нь зүй буйзанаа。Мөн би бээр хэрхэн чамд муу санаа өврөлсөн байх билээ。Хэрэв тийм байсан аваас аль хэдийн тохиорох арга хэмжээ авах байсан бизээ。Өнгөрсөн жилийн хувьд, хэн нэгэн нь “Корий улс Өмнөд Сүн болон Японтой харилцаж баймуй。” гэхийг сонсоод үнэн эсэхийг чамаас асуусан билээ。Гэтэл чи багачуудын үгэнд мунхран, тийм зүйл огт байхгүй гэж хариулсан бөлгөө。

Энэ жил Өмнөд Сүнгийн худалдааны хөлөг Корийд очиход нь чи биднээс далдуур буцаачихаад Явах яамнаас хэл ам гаргахад л сая нэг Явах яаманд үл мэдүүлсэн буруугаа хүлээв。Мөн биднээ дагаар орсон

корийе иргэн Япон руу явна гэхээр нь уулзсанд, дээр үед япончууд Корийд жил бүр алба барьдаг байсан хэмээн үнэнийг өчив。Бас ноднин чи цэргийн хүч татан байлдааны хөлөг хийх үүрэг авсан хэрнээ одоо хүртэл гүйцээж чадаагүйн дээр Им Йөнъ (임연. 林衍) эрх мэдлээ дураар ашигласны улмаас миний санаснаар болсонгүй хэмээн шалтаг тоочиж баймуй。Хэрэв би хожим өчүүхэн хүн дахин томиллоо гэхэд чи яахин дахиж тэр хэргийг зааж хэлж чадахсан билээ?

Чиний улс хэдүй жижиг авч бүтэн улсын ван гэдэг нь тодорхой тул бүхий л шагнах яллах хийгээд зөв бурууг чи л шүүн, шийдэх нь зүй болно。Хэрэв муу хүмүүст гагц эрх мэдэл өгсөн бол бурууг нь зөвхөн чи л үүрэх болой。Тэнгэрийн зүй тогтол алс бөглүү тул арайхан нүүр тулаагүй зүйлийг хэн ч урьдаар мэдэх аргагүй бөгөөтөл хүний талаар хэлэлцэн үзвээс тэдгээр багачууд өөрсдийн дураар чамайг хүртэл сууринаас огцуулаад зогсолгүй тэр тусмаа чиний үр хойчид яахин сайн санаагаар зүтгэх билээ?

Би бээр чамтай хэдийнээ нэгэн гэр бул болсон тул, манай улсын сүр хүчээр холхи улсын иргэдийг хүртэл дагаар оруулбаас зохимуй。Үүнээс хойш Өмнөд Сүн ч бай Япон ч бай ямарваа хэрэг гарах аваас даруй цэрэг, агт морь, байлдааны хөлөг, цэргийн хүнс хангамж хүргэх бүх талын бэлтгэлийг хангагтун。Хэрэв өмнөх шиг ийм тийм шалтаг тоочин хүнд хэцүү хэмээвээс, гавьяа байгуулсугай хэмээн өрсөлдөх хүн маш олон буйг санагтун。»

### 3. 1270 оны өвлийн адагсарын хөхөгчин туулагай өдрийн жуу бичиг 3

“頃以林衍叛逆乃命將出師撫定爾國今罪人殲滅卿宜奠居舊京東方無事矣然念罹玆變故東土之人不無驚擾自茲以往卿其保全生聚諭以朕意毋或妄生猜釁各安其業。”

«Саяхан Им Йөнъ-ий бослогыг дарахын тул жанжин зарж цэрэг ангийг хөдөлгөж чиний улсыг хамгаалан тогтоосон билээ。Эдүгээ ялт хүмүүс бүгд үгүй болсон атال чи хуучин нийслэлдээ амар төвшин сууж гэмээнэ даяар олон амар жимэр болох учиртай。Гэвч бодож үзвээс өнөө хэр энэ мэт зовлон амсаа гэж хөвчин улс ард аюун сочсон нь маргаангүй тул хойшид ард иргэдээ сайтар хамгаалан миний санааг сайн ухуулж, өчүүхэн төдий ч эргэлзээгүйгээр хүн бүр сэтгэл амар аж амьжиргаагаа эрхлэгтүн。»

### 4. 1270 оны өвлийн адагсарын хөхөгчин туулагай өдрийн жуу бичиг 4

“近以高麗權臣構亂乃遣兵東下唯林衍

是問不意脅從詐誤之人妄自疑懼往往逋竄未出或逃往他境因爲叛逆朕之素心務在輯寧爾邦詔諭之後有能自新復歸本國其已往之愆咸當矜釋其中雖有早曾背主逃匿爾國中者亦令安業爲民不許各主認識如或不爾雖悔可追。”

«Сүүлийн үес Корийө улсын эрхэт түшмэл бослого самуун гаргасанд дорно зүг цэрэг илгээсэн нь гагц Им Йөнъ-өөс ял асуух зорилготой бөлгөө. Гэтэл санамсаргүй Им Йөнъ-ий сүрдүүлэгт автаж хүчээр оролцсон хүмүүс мунхагаар эргэлзэх сэтгэл өвөрлөн, ийш тийш дутаан нуугдаад олдохгүй, бусдын хязгаарт дутаан орж үймээн самууны шалтгаан болж баймуй. Миний уг сэтгэл хэзээд чиний улсыг төвшин амгалан байлгахыг хичээх тул энэхүү жуу бичгийг хүлээж аваад өөрийгөө цэнэн ухамсарлаж, эх газар руу буцуаас урьдын бурууг нэг мөр хэлтрүүлмүй. Тэр болтол урьд эзнээсээ урваж Корийө улсад нуугдан буй хэнийг ч болов мөн л ардын хувиар санаа амар аж төрөх бөгөөд тэдгээрийн эзэд хөөн мөшгөхийг үл зөвшөөрмүй. Хэрэв энэхүү тушаалыг эс даваас хожмоо гэмшивч оройтох болой.»

5. 1271 оны хаврын тэргүүн сарын шарагчин туулай өдрийн жуу бичиг

“朕惟日本自昔通好中國又與卿國地相密邇故嘗詔卿道達去使講信修睦爲渠疆吏所梗不獲明諭朕意後以林衍之故不暇及今既輯爾家復遣趙良弼充國信使期于必達仍以忽林赤王國昌洪茶丘將兵送抵海上比國信使還姑令金州等處屯住所需糧餉卿專委官赴彼逐近供給鳩集船艦待於金州無致稽緩匱乏。”

«Миний бодоход Япон улс эртнээс Дундад улс лугаа харилцаж ирсэн бөгөөд, чиний улстай хил хязгаар харилцан ойр тул, урьд чамд заавар өгч элчийг газарчлан, найрамдал тогтооё хэмээсэн бөлгөө. Гэтэл тэр улсын хил сахигч түшмэд саад хийсний уршигаар миний санааг ёсчлон уламжилж чадаагүй ба түүний дараа Им Йөнъ-ий хэрэг явдлын улмаас завдсангүй. Харин эдүгээ чиний тайван амгалан болсон учир дахин Чо Янп<sub>h</sub>ил (조양필. 趙良弼)-ийг элчээр илгээх тул заавал түүнийг Японд хүргэтугэй. Түүнээс гадна К<sub>h</sub>урумчи (쿠룸치. 흘임적. 忽林赤), Ван Гүгч ан (왕국창. 王國昌), Хон Дагу (홍다구. 洪茶丘) нарыг цэргээ удирдан далайн эрэг хүртэл дагалдуулан элчийг буцаж ирэх хүртэл Кымжу зэрэг газраа суулгахаар тогтов. Цэрэг суух хугацаанд шардлагатай цэргийн хэрэгслийг чи хариуцсан түшмэлийг илгээн, ойр орчмын нутгаас

бэлдэн нийлүүлж, хөлөг ба завийг цуглувлан Кымжу (금주. 金州)-д бэлэн байлгаж, явдал удаашрах, гачигдах зүйлгүй болгогтун» [дэлгэрүүлэн үзнэ үү: Солонгос судлал 2016: 63–73].

6. 1271 оны хаврын адаг сарын улаан бар өдрийн жуу бичиг

“朕嘗遣信使通諭日本不謂執迷固閉難以善言開諭此卿所知今將經略於彼有司發卒屯田用爲進取之計庶免爾國他日轉輸之弊仍復遣使持書先示招懷卿其悉心盡慮裨贊方略期於有成以稱朕意.”

«Би урьд элчийг илгээн Японтой харилцах хэмээтэл санамсаргүй мунхаглан зөрүүдэлж, хаалгаа чанд хаасны улмаас эдүгээ уран үгээр ятган сэнхрүүлэхэд бэрх болсныг чи ч сайн мэдэх буй за. Эдүгээ тэднийг захирахын тулд холбогдох тамгын газарт нь зааварчлан албаны тариа тарих цэрэг илгээж хожим тийш довтлохоор төлөвлөсөн болно. Энэ нь цаашид чиний улсыг цергийн хэрэглэл хангамж нийлүүлэх зовлонгоос ангижруулах гэсэн санаа болой. Тиймээс дахин жуу бичиг бүхий элчийг зарж юуны өмнө хaan миний бодлыг ухуулахул чи гагц нэгэн үзүүрт сэтгэлээр миний арга төлөвлөгөөнд туслан тус ажлыг бүтээхийг хичээн миний санаанднийцүүлэгтүн.»

7. 1271 оны хаврын адаг сарын харагчин мөгий өдрийн жуу бичиг

“王所奏陳朕悉知之嚮王在國中猶有姦人生事今叛人未靖王不可來朝.”

«Чиний айлтгасан саналыг би сайтар ойлголоо. Урьд чамайг гурнээ бараалхан ахуйд зальхай этгээдүүд гай түйтгэр авч ирсэн нь одоо урван тэрслэгчид дарагдаагүйн дээр ван чи бараалхаар ирэх нь тохиромжгүй баймуй.»

8. 1271 оны зуны эхэн сарын улаагчин мөгий өдрийн жуу бичиг

“據忻都白羊奏請添遣軍馬比及暑雨前討平逆賊朕以爲暑雨之前軍馬未能到彼卿宜於旁近簽軍六千人分附攻取珍島若事早畢於卿百姓便益.”

«Хинъду (현도. 흔도. 忻都), Баян (바얀. 백양. 白羊) нар цэрэг морины хучийг зузатган халуун нар, борооны улирал эхлэхээс урьтаж хулгайг дайлан төвшитгөсүгэй хэмээн гүйн айлтгажухуй. Би санаваас, зун борооны улирал болохоос өмнө их цэргийг тэнд хүрч эс чадмуй. Ван чи ойр орчмын нутгаас 6000 цэрэг татаж, харьяа цэрэгт нь хуваан бүрдүүлээд Чинъдо (진도. 珍島)руу давшин эзлэн автугай. Хэрэг явдал хурдан дуусах аваас танай ард иргэдэд ч тустай буюу»

9. 1271 оны зуны адаг сарын улаан бич өдрийн жуу бичиг

“卿嚮遣印公秀奏曰：‘小邦蓄積就陸之日悉爲逆賊攘奪又因供億王師罄盡無餘歟及中外臣民甚爲艱窘而又耕牛不畜難於徵索。’乃有司前往體問卿方上表謂軍馬接秋糧餉限以力盡不令受飢屯田農牛農器等漸次當依元數則前奏豈非虛妄且匹夫一言不誠尙恐不爲人所信卿一國臣民之主數奏不實可乎爾後慎勿如此卿又云：‘吾之民亦是皇帝之民也使其失業不堪勞苦則恐有貳於盜賊若不揆力陳實早達于宸所以至困窮誰任其責？’蓋由爾國不逞之人肆爲叛逆以致軍民之勞既爲一家初無內外之間如撫定之後豈坐視人民困苦而不加恤哉尙體至仁益殫誠赤。”

«Ван чи саяхан Инъ Гонсү (印公秀)-г илгээн, “Манай улсаас хураасан хөрөнгийг эх газарт хүргэх үес бүгдийг дайсанд булаалгасны дээр, басхүү их улсын цэргийн хангамж хэрэглэлийг базаахын тул юу ч үлдсэнгүй. Улсын бүхий л түшмэл ардуудаас эд зүйл хурааж авахад туйлын бэрх бөгөөд тариаланд хэрэглэх үхэр байхгүй учир түүнийг ч мөн хураахад хүч хүрэхгүй байна.” хэмээн айлтгасанд харьяа яамнаа тушаан биеэр очиж магадал хэмээсэн болно.

Гэтэл сая ирүүлсэн айлтгалдаа чи өөрөө “Их улсын цэргийг намар болтол хэрэгцээт хүнсээр чадлын хэрээр хангаж, өлсгөж цангаалгүй, албан тариаланд шаардлагатай үхэр болон тариалангийн багаж хэрэгсэл зэргийг мөнхүү тоогоор нь нийлүүлэх төлөвтэй байна.” хэмээсэн нь урьд айлтгасан үг чинь худал байсныг харуулж буй хэрэг биш үү? Хэрэв дорд хүмүүн бөгөөс гагц үг үнэн очиж эс чадах ахул бусдууд үл итгэх вий хэмээн эмээдэг атал, тэр тусмаа ван чи нэгэн улсын эзэн атлаа худал үг хэлж болно гэж үү? Үүнээс хойш энэ мэт хэрэг гаргахаас болгоомжлогтун. Мөн чи “Манай ард иргэд ч мөн хуанди таны ард иргэд байтал тэдний амь зуулгыг булаан тэр зовлонгоос гэтлэх аргагүйд хүргэвээс хulgай дайсны зүг сэтгэл хандуулахгүй гэх газаргүй. Та “Яахин байдлыг сайтар нягталж аль хэдийн надад үнэнийг илтгэлгүй ард иргэдийг минь ийм гаслант байдалд оруулж чадав?” хэмээх учир хэн түүний хариуцлагыг хүлээх хэрэг билээ? гэж өчсөн нь бий.”

Би санааваас, чиний улсын дуулгаваргүй этгээдүүд аюумшиггүйгээр бослого самуун дэгдээсний улмаас цэрэг иргэд энэ мэт зовлон зүдгүүр амсаж буй хэрэг биш үү?

Хоёр улс хэдийн нэгэн гэр бүл болчиход угаас гадна дотно ялгалгүй хамгаалан тогтоосны дараа хэрхэн ард иргэдийн зовлон зүдгүүрийг тоон харгалзахгүй байх билээ? Хаан миний туйлын өршөөх сэтгэлийг чанд ухаж улам их хичээн зүтгэгтүн.»

10. 1271 оны намрын эхэн сарын улаан бар өдрийн жуу бичиг

Жуу бичгийн утга агуулгын тухайд тэмдэглэсэн зүйл үгүй.

11. 1272 оны зуны эхэн сарын цагаан бар өдрийн жуу бичиг

“譯語別將徐校尉金貯使日本有功宜加大職.”

«Orchuulgын тусгай жанжин (역어별장. 譯語別將) Сө Чин (서칭. 徐), кийо-вүй (교위. 校尉) Ким Жө (김저. 金貯) нар Япон руу элчээр одож гавьяа байгуулсан тул өндөр албанд дэвшүүлэгтүн.»

12. 1272 оны өвлийн адаг сарын хөхөгчин хонь өдрийн зарлиг

元以攻討濟州詔王簽軍六千水手三千.

«Юань улс Чэжу (제주. 濟州)-г дайлахаар ванд “6 000 цэрэг, 3 000 усчин шалгаруул” хэмээн зарлиг буулгав.»

13. 1273 оны хаврын тэргүүн сарын хар нохой өдрийн жуу бичиг

元使來王迎詔于宣義門其文用新制蒙古字人無識者使者云：“因林惟幹所奏求火熊皮也.”

«Юань улсын элчийн авч ирсэн хуандигийн жууг ван Сөнъ-ый хаалга (선의문. 宣義門)-нд угтан авсан боловч шинэ зохиосон монгол үсгээр бичсэн тул тайлах хүн байсангүй. Иймд элч Им Йугань (임유간. 林惟幹)-д “Хүрэн баавгайн арьс ол” гэсэн утгатай хэмээн шивнэв.»

14. 1273 оны хаврын дунд сарын хөхөгчин тахиаөдрийн жуу бичиг

黃鳳州經略使差人齋元詔來令僧徒出迎其詔云：“禁軍土搔擾僧舍損毀經像使之安心作法.”

“”Юань улсын цэргүүд сүм хийдэд үймээн шуугиан дэгдээж судар ном, бурхан шүтээнийг сүйтгэхийг хориглосон тул лам хуврагуудыг сэтгэл амар байж, бурхны номоо айлдагтун» гэсэн агуулгатай байлаа.

15. 1273 оны хаврын дундсарын улаан бич өдрийн жуу бичиг 1, 2

忻都劉統領萬戶鄭溫朴古大等來自塩州屯所傳詔二通一以忻都等領軍討耽羅一禁官軍擅奪良家女爲婢又聽自制兵仗從王請也.

16. 1273 оны хаврын дундсарын улаан бич өдрийн жуу бичиг 1, 2

1- «Хиньдү нараар удирдуулан Т<sub>x</sub>амра (탐라. 毀羅)-г дайлах.»

2- «Юань улсын түшмэл цэргүүд сайн хүмүүний (= сайн айлын) бүсгүйчүүлийг булаан шивэгчин болгож буйг хориглосон, Корийө улсын вангийн хүсэлтээр тус улсбие даан зэр зэвсэг хийхийг зөвшөөрсөн» тухай агуулгатай.

17. 1273 оны зуны дунд сарын хар бич өдрийн жуу бичиг

元冊封皇后太子遣使頒詔.

«Юань улс их хатан болон тайжид өргөмжлөл хүртээсэн тухай элч илгээн мэдүүлсэн.»

18. 1274 оны зуны дунд сарын цагаан хулгана өдрийн жуу бичиг

元遣使詔勸課農桑儲峙軍糧仍命洪茶丘提點農事.

«”Юань улс газар тариаланг дэмжиж цэргийн хүнс нөөцөл” хэмээсэн жуу илгээв.»

19. 1274 оны намрын дунд сарын шрагчин мөгий өдрийн жуу бичиг

“國王在日屢言世子可以承替今命世子承襲國王勾當凡在所屬並聽節制.”王受詔畢謁景靈殿還御康安殿服黃袍卽位受群臣朝賀仍宴詔使詔使以王駙馬推王南面詔使東向達魯花赤西嚮坐王行酒詔使拜受飲訖又拜達魯花赤立飲不拜詔使曰：“王天子之駙馬也老子何敢如是吾等還奏汝得無罪耶?”曰：“公主不在且此先王時禮耳.”

«Улсын ван амьд ахуйдаа ширээ залгамжлах хөвгүүн (чамайг. орч) ван ширээ залгамжилж чадмуй хэмээн удаа дараа хэлж билээ. Тиймээс одоо ширээ залгамжлах хөвгүүн (чи. орч) улсын ван суурийг залган, албаа гүйцэтгэгтүн хэмээн зарлиг буулгаж буй тул түүнд харьялагдсан бүхий л ард иргэд түүний захирагааг чандлан дагагтун.»

20. 1275 оны зуны дунд сарын хөх нохой өдрийн жуу бичиг

Жуу бичгийн утга агуулгын тухайд тэмдэглэсэн зүйл үгүй.

21. 1275 оны зуны адаг сарын улаан луу өдрийн жуу бичиг

元遣使詔赦耽羅賊黨逃匿州縣者.

«”Юань улс элч илгээн “Үрьд Т<sub>x</sub>амра—д [бослого гаргасан-орч.]хулгайн намын до-троос жүхийн (주현. 州縣, чжоу, сянь-орч.) рүү зайлан нуугдагсдыг ялаас чөлөөлсүгэй.” гэсэн жуу ирүүлэв.»

22. 1275 оны өвлийн эхэн сарын цагаан нохой өдрийн жуу бичиг

“爾國諸王氏娶同姓此何理也?既與我爲一家自宜與之通婚不然豈爲一家之義哉!且

我太祖皇帝征十三國其王爭獻美女良馬珍寶爾所聞也王之未爲王也不稱太子而稱世子國王之命舊稱聖旨今稱宣旨官號之同於朝廷者亦其比也又聞王與公主日食米二升此則宰相多而自專故耳凡此皆欲令爾知之非苟使爾貢子女革官名宰相也. 黑的來言爾國事非一並不聽許爾其知之.”

«Танай улсын Ван овогтынхон овог до-троо худ ураг болдог нь зүйд үл нийцмүй. Хэдийн бидэнтэй нэгэн гэр бүл болсон тул бидэнтэй ураг холбох нь зүйтэй бөгөөд эс тэгвээс юунд нэгэн гэр бүлийн хувиар ёс журмыг дагах тухай ярьж болохсон билээ? Мөн манай Т<sub>x</sub>айзу хуанди (Чингис хаан. орч) 13 улсыг эзэлмэгц тэр улсын ванггууд бие биеэсээ өрсөн үзэсгэлэн гоо бүсгүй, аргамаг хүлэг, ховор эрдэнэс өргөн барьсныг чи ч бас сонссон буй за.

Ван чамайг хараахан сууринд суухаас өмнө тайж хэмээлгүй, ширээ залгамжлагч гэсэн бөгөөд улсын вангийн зарлигийг урьд“сөнжи” гэдэг байсныг “сөнъжи” гэх болсон тул түшмэлийн нэр цолын дотроос манай засаг газартай адил зүйлсийг ч мөн халж хэрэглэх нь зүйтэй.

Сонсвоос ван гүнж хоёр хоногт 2 аяга тутарга л иддэг хэмээмүй. Үүний учир болбоос тэргүүн сайд олон тул тэд төрийн эрхийг атгаж буйтай холбоотой амуй. Энэ мэт жишээ хэлж буй нь цөм гагцхүү чамд сануулах гэсэн санаа атал үүнийг ойлголгүй чи хөвгүүд охидоо өргөн барьж, түшмэлийн нэр цолыг өөрчилж, сайд нарыг багасга гэсэн үг биш билээ. Хэйдэ (흑적. 黑的) ирээд хэлэхдээ чиний улсад засан залруулбаас зохих хэрэг ганц хоёроор тогтохгүй хэмээсэн боловч хаан би бүгдийг сонсож зөвшөөрөгүй гэдгийг чи мэдэх буй за.»

23. 1276 оны хаврын тэргүүн сарын улаагчин үхэр өдрийн жуу бичиг

“四時不忒推鳳曆以紀年萬國攸同矧雞林之受朔若稽舊典用布大和今賜至元十三年曆日一本卿其敬授農時益遵田正籍爾蕃宣之力贊于平秩之功率勤南畝之民罔知遊惰爰俾東陲之俗丕變雍熙庶績其凝朕言無替.”

«Эргэх дөрвөн улирлын эргэлт нь ямхын зөрүү үгүй бөгөөд цаг тооны бичгийн дагуу жил сар өдрийг тэмдэглэхүй нь түмэн улсад адил бөлгөө. Тэр тусмаа Корийө улс нь чөнсаг (정삭. 定朔)<sup>4</sup>-ийг хүртэхүй ньэртнээс инагши уламжлан ирсэн ёс журмын дагуу амар амгалан цаг үеийг нээхүйн хэрэг ахул Жи-юань-ы 13-р оны цаг тооны бичиг шаг-

<sup>4</sup> Цаг тооны бичиг үйлдэх ёс.

насугай. Иймд ван чи тариалангийн ажил эхлүүлэх цаг өдрийг сургаж, эрт цагт тариаланч түшмэл байгуулсныг чандлан дагаж, эзний хувиар алба үүргээ гүйцэтгэн хаан надад тусалж гавьяа байгуултугай. Тарианы газар үр суулгах тариачдыг хойш суулгүй шургуу ажиллуулж алс зүүн нутгийн зан заншлыг сайхан өөрчилбөөс бүхий гавьяа бүтэх тул миний үгийг бүү зөрчигтүн.»

24. 1276 оны зуны дунд сарын хөхөгчин мөгий өдрийн сургах зарлиг

將軍高天伯自元還帝停親朝.

«Ко Чөнъбайг (고천백. 高天伯) жанжин Юань улсаас эргэн ирж, ванг гүрнээ айлчлахыг азна хэмээсэн хуандигийн зааврыг уламжлав.»

25. 1276 оны намрын адаг сарын цагаан бич өдрийн жуу бичиг

元以平定江淮遣不花來詔赦天下.

«Юань улс Цзянхуай (강회. 江淮) нутгийг төвшитгэн тогтоогоод, Буха (부카. 부화. 不花)-г илгээн тэнгэрийн доор (дэлхий дахинд-орч.) өршөөх зарлиг буулгав.»

26. 1276 оны өвлийн эхэн сарын хөххулгана өдрийн зарлиг

元遣忽刺命王及公主以明年五月入朝又移放羅州馬於珍島又罷合浦鎮邊所稍工水手又令西海道歸附軍自耕而食.

«Юань улс Хуладай (쿠라다이). 홀자대. 忽刺1250–1311<sup>5</sup>-г илгээн ван, гүнж нарт ирэх оны зуны дунд сард гүрнээ айлчлахыг заахын сацуу Нажу (나주. 羅州)-гийн морьдыг Чинъдо (진도. 珍島) руу шилжүүлж адгуулував. Мөн Хабп<sup>x</sup>ожиньбийнъсо (합포진변소. 合浦鎮邊所)-гийн урчууд, далайчдыг албанаас чөлөөлж, Сохай до (서해도. 西海道)-гийн дагаар орсон цэргийг өөрсдөө тариа тарьж, хүнс болгогтун хэмээн зарлиг буулгав.»

27. 1276 оны өвлийн эхэн сарын шарлуу өдрийн жуу бичиг

金方慶受虎頭金牌仍齋詔書還王出城以迎.

«Ким Бангийн барсын толгойт алтан пайз (호두금패. 虎頭金牌), жуу өвөртлөн буцаж ирсэндван хотоос гарч угтав (жуу бичгийн эх нь сурвалжид байхгүй).»

28. 1278 оны хаврын тэргүүн сарын хархулгана өдрийн жуу бичиг

郎將李仁齋頒曆詔還自元. 王出迎于城外.

«Нанжан (낭장. 郎將) И Инь (인인. 李仁) цаг тооны бичгийг зарлан тунхагласан жуу

бичиг өвөртлөн Юань улсаас буцаж ирсэнд ван хотын гадна гарч угтав (жуу бичгийн эх нь сурвалжид байхгүй).»

29. 1278 оны хаврын дунд сарын шарагчин туулай өдрийн жуу бичиг

元遣闢闢等來頒詔.

«Юань улсаас Хөхдэй (코코다이). 활활대. 闢闢나) нарыг илгээн жуу бичиг тархав.»

30. 1278 оны хаврын адаг сарын хөх морь өдрийн зарлиг

印侯還自元帝召還洪茶丘又命王入朝.

«Инь Хү (인후. 印侯) Юань улсаас буцаж ирсэнд түүгээр хуанди Хон Дагу-г дуудсан агаадбас ванг гүрнээ айлчлах зарлиг буулгав.»

31. 1279 оны хаврын тэргүүн сарын хөхөгчин туулай өдрийн жуу бичиг

“朕若稽天象敎授人時所以大一統重民事也.卿世守藩方歲修貢職宜頒新朔用示同文尙驅東作之民勉率西成之.”

«Би тэнгэр эрхэсийн зорчлыг илтгэх эргэх улирлыг тэмдэглэсэн цаг тооны бичгийг тунхаглаж буй нь дэлхий өртөнцийг нэгтгэх үүргээ улам өргөжүүлж ард олныхоо аж ахуйг эрхэмлэдэгт оршмуй. Түшмэл/ван/ чи үе улиран (миний — орч.) хайгуул халхавч (хараат улс — орч.)-ийг сахин жил бүр алба өргөж ирсэн тул зүй нь шинэ цаг тооны бичиг соёрхсон тул бидэнтэй “бичиг нэгэн (동문. 同文)”<sup>6</sup> хүндлэл үзүүлсүгэй. Хавар тариачин ардуудыг тариалангийн ажилд хүчээ дайчлан, намар арвин их ургац хураалгахын тулд хичээгтүн.»

32. 1280 оны хаврын адаг сарын шарморь өдрийн жуу бичиг

元遣蠻子海牙來帝禁郡國舍匿亡軍回回恣行屠宰.

«Юань улсаас хятадын өмнөд нутгийн хүн Хайя (카야. 海牙)-г илгээн хуандийн зарлигийг уламжилсан агаад хятад газрын күнь болон харьяа улсаас дутаасан цэрэг, уйгарчуудыг дураар мал нядлахыг хориглогтун хэмээжүүхий.»

33. 1280 оны намрын дунд сарын цагаагчин гахай өдрийн сургах зарлиг

將軍朴義還自元帝王親朝.

«Жанжин Паг Ый (박의. 朴義) Юань улсаас буцаж ирэхэд түүгээр хуанди ванг гүрнээ айлчлах зарлиг буулгажээ.»

34. 1280 оны өвлийн адаг сарын цагаагчин туулай өдрийн жуу бичиг

帝冊王爲開府儀同三司中書左丞相行中

<sup>5</sup> Дэлгэрүүлэн үзнэ үү: [Хань Жөнхий 2008: 47; Г. Эрдэнэчимэг 2016: 67–76].

<sup>6</sup> Адил бичиг үсэг хэрэглэж, нэг соёлын хүрээнд багтах гэсэн утга.

書省事賜印信.又以金方慶爲中奉大夫管領高麗軍都元帥;知密直司事朴球金周鼎爲招勇大將軍左右副都統並賜虎頭金牌印信;趙仁規爲宣武將軍王京斷事官兼脫脫禾孫賜金牌印信;朴之亮等十人爲武德將軍管軍千戶賜金牌及印;趙抃等十人爲招信校尉管軍摠把賜銀牌及印;金仲成等二十人爲忠顯校尉管軍摠把。

«Хуанди ванг кайфу итунсаньсы (개부의동삼사. 開府儀同三司), төв бичгийн му-  
жийн зүүн этгээдийн чэнсян (중서좌승상. 中書左丞相), хайнжуңсөөнса (행중서성사. 行中書省事)-аар соёрхон, тамга шагнажээ.  
Мөн Ким Бангйөн-ийг чүнбондайбү (중봉대부. 中奉大夫), Корйө-гийн цэргийг за-  
хирах дуюаньшуй (관령고려군도원수. 管領高麗軍都元帥)-гаар, чимилижигсаса (지밀  
직사사. 知密直司事) Паг Гү (박구. 朴球),  
